БАТЛАВ: БАРУУНБҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.ОТГОНБААСАН

БАРУУНБҮРЭН СУМЫН ҮЕРИЙН ДАЛАНГИЙН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 – 05- 01 № 02 Сэлэнгэ аймаг

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр - Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2025 -2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр - Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын Засаг даргын 2025 -2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
2.	Байршил, газар эдэлбэрийн одоогийн байдал	- Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сум /Хавсралт зураг 1/ - Баруунбүрэн сумын одоо байгаа үерийн далан, суваг нь 2024 онд ЗДТГ болон аж ахуй нэгжийн оролцоотойгоор хийгдсэн 1 км урттай шороон далантай .
3.	Зураг төсөл боловсруулах үе шат хугацаа	- Бэлтгэл ажил (инженер геологийн дүгнэлт, дэвсгэр зургийн тодруулга, ерөнхий төлөвлөгөө) - Ажлын зураг төсөл, төсөв.
4.	Ажлын зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<u>Монгол Улсын хуулиуд:</u> - Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль; - Хот байгуулалтын тухай хууль; - Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай; - Газрын тухай болон Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль; - Усны тухай хууль; - Авто замын тухай хууль; - Инженерийн бэлтгэл арга хэмжээ ; <u>Норм, нормативууд:</u> - Хот,тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм (БНбД 30-01-04); - Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт /БНбД/ - Хот суурины гудамж, зам төлөвлөлт (БД 32-01-04); - Хот тосгон нутаг дэвсгэр, зам талбайгаас бороо, цасны усыг зайлуулах ажлын зураг төсөл, тооцооны норм /БД 40-302-13/ - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм, норм, дүрэм, заавар. Холбогдох журмууд: - Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 04 –ний өдрийн 317 дугаар тогтоол “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”

		- Усны барилга байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам /БНбД 33-01-03/ - Бусад холбогдох норм, дүрэм, заавар
5.	Ажлын зураг төслийн бүрдэл	Шинээр барих үерийн хамгаалалтын далан: - Баруунбүрэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд туссан үерийн хамгаалалтын далан, сувгийн төлөвлөлт болон шинэ суурьшлын бүсийн ар талаар нийт 3,5 км бетон үерийн хамгаалалтын далан, суваг шинээр хийх /захиалагч байгууллагатай зөвшилцөх/ - Баруунбүрэн сумын хамгаалалтын далан, сувгийн урд хэсэг буюу суурьшлын бүс дотор үерийн ус, цас, борооны уснаас хамгаалах хаалттай 2 км сувгийг судалгаа тооцооны үндсэн дээр шинээр хийх. /захиалагч байгууллагатай зөвшилцөх/ - Баруунбүрэн сумын авто замын ус зайлуулах байгууламжийг одоогийн нөхцөл байдал болон цаашдын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан судалгаа, тооцоо хийж шинээр 10км хаалттай суваг төлөвлөх. /захиалагч байгууллагатай зөвшилцөх/ - Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн хийц, зохиомж, дагалдах хийцийн тооцоо, ажлын зураг боловсруулах. - Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн трассанд өртөж байгаа нэгж талбаруудыг зурагт тэмдэглэж газар чөлөөлөлтийн зардал тооцох, холбогдох байгууллагуудтай зөвшилцөх, зураг схем гаргаж өгөх, статистик мэдээлэл гаргах. - Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ашиглалт, техникийн засвар үйлчилгээнд зориулан автомашины болон явган хүний гарц төлөвлөх. - Үерийн хамгаалалтын барилга байгууламж авто замтай огтлолцож байгаа хэсэгт нэмэлт арга хэмжээ төлөвлөх, явган хүний зам, гүүрэн гарц, хайс хашлага тохижилт төлөвлөх. - Баруунбүрэн суманд хэрэгжиж байгаа, хэрэгжихээр төлөвлөгдөж байгаа Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын төсөл хөтөлбөрүүдтэй уялдуулах. <u>Баримт бичгийн иж бүрдэл:</u> - Тайлбар бичиг /эх хувь 1, хуулбар хувь 2/ - Одоогийн байдлын судалгаа /эх хувь 1, хуулбар хувь 2/ - Хөрөнгө оруулалтын тооцоо төсөв /эх хувь 1, хуулбар хувь 2/ - Улсын магадлалаар орсон иж бүрэн ажлын зураг төсөл /эх хувь 1, хуулбар хувь 2/ - Дэвсгэр зураг, зай хэмжээ, өндөржилт / М1:500 / - Магадлалын нэгдсэн дүгнэлт. <u>Зургийн иж бүрдэл</u>

		- Нүүр хуудас /батлагдах/ - Байршлын схем М1:2000 - Одоогийн байдал М1:500-1000 - Ерөнхий төлөвлөгөө М1:1000-500 /батлагдах/ - Дэвсгэр зураг М1:500-:1000 - Зай хэмжээ М1:500 - Өндөржилт М1:500 <u>Зураг төсөлд тавигдах шаардлага:</u> - Хот байгуулалтын мэдээллийн сангийн стандартыг мөрдөх - Хийгдэж буй төслийн дэвсгэр зургийн UTM WGS-84-48N, буюу солбицлын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэнэ. - Ажлын зурагт бусад инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийг нэг дэвсгэр дээр нэгтгэн хоорондын зай хэмжээг огтлолын зургаар тодорхой үзүүлж, норм стандартын дагуу төлөвлөж, холбогдох байгууллагуудтай зөвшилцсөн байх шаардлагатай. - Ажлын зураг, тайлбар бичиг, инженер геологийн дүгнэлт, геодезийн ажлын тайлан бусад холбогдох бичиг баримтыг эх хувь 1, хуулбар хувь 2 /хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах/, тоон хэлбэрээр /DWG болон PDF/ хүлээлгэж өгнө.
6.	Архитектурын төлөвлөлтөд тавигдах шаардлага	- Архитектур төлөвлөлтийн шийдлийг хот төлөвлөлтийн норм дүрмийн дагуу төлөвлөх. - Нийгмийн дэд бүтэц, хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн, Баруунбүрэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө норм дүрмийн дагуу хүчин чадлыг нарийвчлан тогтоох. - Үерийн далан, суваг, авто зам, шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг тогтоох.
7.	Эдийн засгийн тооцоо, төсөв	- Төсвийг ESTIMATOR-PRO программ болон түүнтэй ижил төрийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцно.
8.	Зураг төсөл боловсруулах хугацаа	- Гэрээ байгуулснаас хойш 60 хоног
9.	Зураг төсөл боловсруулах байгууллага	- "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу;
10.	Зураг төслийн санхүүжилт	- Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын Засаг даргын Тамгын газар
11.	Төслийн захиалагч	- Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын Засаг даргын Тамгын газар
12	Байгаль орчны үнэлгээ	- Байгаль орчны ерөнхий үнэлгээ хийлгэх. - Шаардлагатай тохиолдолд байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэх.

14	Онцгой нөхцөл (Төлөвлөлтийн шаардлагаар гарах нэмэлт шаардлагууд трассын дагуух газар чөлөөлөх, хөрсний шинж чанараас хамаарсан нэмэлт төлөвлөлт, шинэ техник технологи хэрэглэх гэх мэт)	- Трассын дагууд огтлолцож байгаа инженерийн шугам сүлжээ, цахилгаан дамжуулах шугам, интернетийн шилэн кабелийг хамгаалах, бэхлэх өргө хэмжээг төлөвлөж, эзэмшигч байгууллагуудтай зөвшилцөх, шаардлагатай тохиолдолд шугам сүлжээг шилжүүлэх зургийг боловсруулах. - Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн инженерийн тооцоог хамгийн боломжит хувилбарыг сонгож сүүлийн үеийн орон нутагт тохирсон дэвшилтэт технологи ашиглан аль болох бага зардалтай байхаар төлөвлөж зураг төсөвт тусгах. - Үерийн хамгаалалтын барилга байгууламжид нийлэх гуу жалга түүний оруулга, бэхэлгээний хийц, уруйн үерийн хурд сааруулах байгууламжийн тооцоо зураг төсөвт тусгах. - Авто замтай огтлолцож байгаа хэсэгт нарийвчилсан тооцоо гаргаж байгууламжийг төлөвлөх.
15	Зөвшилцөх байгууллагууд	- Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын Засаг дарга; - Сэлэнгэ аймгийн ерөнхий архитектор; - Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар; - Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газар; - Холбогдох инженерийн шугам сүлжээний байгууллагууд;

ХЯНАН ЗӨВШӨӨРСӨН:

1. СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР Б.ХАНГАЛ

БОЛОВСРУУЛСАН:

1. БАРУУНБҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Н.АЛТАНЦЭЦЭГ